



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/053/НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор Д.Эрдэнэбулган Утас: 89818085 Цахим хаяг: Erdenebulgandab@audit.gov.mn |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| Асуудлыг онцолсон хэсэг | 3 |
| Аудитын гол асуудал | 3 |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 7 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 13 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 15 |
| 4.1 Ерөнхий зүйл | 15 |
| 4.2 Материаллаг байдал | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 16 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 16 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 16 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 16 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 17 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 17 |
| 5.1 Төлбөрийн акт | |
| 5.2 Албан шаардлага | |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 18 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/59

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

5020313

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭВГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>66,814,802.09</u> | <u>56,055,591.73</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 15,920,042.36 | 87,000.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 15,920,042.36 | 87,000.00 |
| 3121 | Төгрөг | 15,920,042.36 | 87,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 15,833,042.36 | 00.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 87,000.00 | 87,000.00 |
| 33 | АВЛАГА | 1,187,781.00 | 2,027,755.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 839,974.00 |
| 335 | Бусад авлага | 1,187,781.00 | 1,187,781.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,187,781.00 | 1,187,781.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 49,706,978.73 | 53,940,836.73 |
| 354 | Хангамжийн материал | 49,706,978.73 | 53,940,836.73 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 797,350.00 | 872,350.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,224,906.01 | 48,083,764.01 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,093,985.72 | 2,393,985.72 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,590,737.00 | 2,590,737.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,853,523,282.44</u> | <u>1,842,207,812.84</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,853,523,282.44 | 1,842,207,812.84 |
| 392 | Биет хөрөнгө | 1,759,523,282.44 | 1,747,841,146.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 741,212,563.88 | 743,572,563.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -55,929,955.66 | -75,227,839.06 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19,000,000.00 | 19,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -19,000,000.00 | -19,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 158,254,945.01 | 173,445,945.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -51,248,243.46 | -61,408,944.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 57,812,722.22 | 62,559,722.22 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -36,404,747.55 | -41,105,849.16 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 941,723,994.00 | 941,723,994.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9,852,755.00 | 10,041,755.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -9,852,755.00 | -9,862,205.00 |
| 39217 | Ном | 4,102,004.00 | 4,102,004.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 94,000,000.00 | 94,366,666.67 |
| 39301 | Програм хангамж | 1,070,000.00 | 1,470,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,070,000.00 | -1,103,333.33 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 94,000,000.00 | 94,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,920,338,084.53</u> | <u>1,898,263,404.57</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>4,932,880.57</u> | <u>00.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | <u>4,932,880.57</u> | <u>00.00</u> |
| 413 | Өглөг | <u>4,932,880.57</u> | <u>00.00</u> |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,932,880.57 | 00.00 |

| | | | |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,915,405,203.96 | 1,898,263,404.57 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,915,405,203.96 | 1,898,263,404.57 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 479,572,191.72 | 479,572,191.72 |
| 51101 | Өмч: - төрийн | 479,572,191.72 | 479,572,191.72 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 902,018,960.71 | 884,877,161.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 902,018,960.71 | 902,018,960.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -17,141,799.39 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 533,814,051.53 | 533,814,051.53 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,920,338,084.53 | 1,898,263,404.57 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 658,836,567.74 | 633,792,838.33 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 149,359,646.01 | 12,425,760.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 149,359,646.01 | 12,425,760.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 87,399,126.01 | 12,425,760.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,654,000.00 | 2,425,760.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 85,745,126.01 | 10,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 509,476,921.73 | 621,367,078.33 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 405,544,121.73 | 527,859,478.33 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 405,544,121.73 | 527,859,478.33 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,081,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,081,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 91,851,800.00 | 93,507,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 91,851,800.00 | 93,507,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 485,807,772.05 | 650,934,637.72 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 485,807,772.05 | 650,934,637.72 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 440,049,399.74 | 607,946,547.16 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 261,786,859.08 | 389,945,066.52 |
| 210101 | Үндсэн цалин | 261,786,859.08 | 253,732,868.75 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 104,139,657.77 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 14,620,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 17,452,540.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,149,000.96 | 47,371,414.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,149,000.96 | 33,252,669.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 3,912,078.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,939,539.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 1,653,424.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 6,613,701.99 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 72,724,089.69 | 88,662,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,908,031.49 | 6,212,264.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210302 | Түлш, халаалт | 69,156,058.20 | 81,560,336.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 660,000.00 | 890,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,554,749.28 | 5,802,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,033,600.00 | 1,092,538.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,697,989.28 | 2,100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,263,160.00 | 1,275,562.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 510,000.00 | 1,334,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,341,616.38 | 5,542,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 110,000.00 |
| 210602 | Тавилга | 18,666.38 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,322,950.00 | 5,432,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 616,000.00 | 2,580,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 616,000.00 | 2,580,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,904,000.00 | 32,940,397.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,724,000.00 | 31,425,764.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 600,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.00 | 914,633.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,973,084.35 | 35,102,469.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,691,100.00 | 900,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,281,984.35 | 34,202,469.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,758,372.31 | 42,988,090.56 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 43,630,662.00 | 26,258,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,808,400.00 | 11,690,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 17,342,262.00 | 14,568,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 480,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 16,619,290.56 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 16,619,290.56 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,127,710.31 | 110,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,127,710.31 | 110,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 173,028,795.69 | -17,141,799.39 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 173,028,795.69 | -17,141,799.39 |



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 511,130,921.73 | 623,792,838.33 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,654,000.00 | 2,425,760.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,654,000.00 | 2,425,760.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,654,000.00 | 2,425,760.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,654,000.00 | 2,425,760.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 509,476,921.73 | 621,367,078.33 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 405,544,121.73 | 527,859,478.33 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 405,544,121.73 | 527,859,478.33 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,081,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,081,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 91,851,800.00 | 93,507,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 91,851,800.00 | 93,507,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 497,008,279.58 | 616,738,880.69 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 497,008,279.58 | 616,738,880.69 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 451,249,907.27 | 570,657,690.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 261,561,039.58 | 391,035,935.13 |
| 210101 | Үндсэн цалин | 167,840,428.76 | 239,453,508.19 |
| 210102 | Нэмэгдэл | 59,116,722.92 | 104,644,893.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,945,997.30 | 15,560,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,657,890.60 | 31,377,533.94 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,126,368.00 | 48,960,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,141,900.00 | 33,292,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,252,000.00 | 3,916,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,801,700.00 | 1,958,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 450,400.00 | 1,958,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,480,368.00 | 7,833,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 72,724,089.69 | 88,662,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,908,031.49 | 6,212,264.00 |
| 210302 | Түлш, халаалт | 69,156,058.20 | 81,560,336.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 660,000.00 | 890,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,571,360.00 | 6,513,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,101,000.00 | 1,738,338.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,531,100.00 | 1,800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,429,260.00 | 1,175,462.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 510,000.00 | 1,800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,531,700.00 | 5,951,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,531,700.00 | 1,006,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,000,000.00 | 4,945,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 616,000.00 | 2,580,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 616,000.00 | 2,580,000.00 |

| | | | |
|--------|---|---------------|----------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,295,850.00 | 25,714,055.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,115,850.00 | 24,099,322.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 600,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.00 | 1,014,733.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,823,500.00 | 1,240,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,823,500.00 | 1,240,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,758,372.31 | 46,081,190.56 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 43,630,662.00 | 29,351,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 3,093,100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,808,400.00 | 11,690,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 17,342,262.00 | 14,568,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 480,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 16,619,290.56 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 16,619,290.56 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,127,710.31 | 110,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,127,710.31 | 110,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 14,122,642.15 | 7,053,957.64 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 22,887,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 22,887,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 22,887,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 22,887,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | -22,887,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 14,122,642.15 | -15,833,042.36 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,797,400.21 | 15,920,042.36 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 15,920,042.36 | 87,000.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нооц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| C01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 479,572,191.72 | 534,444,968.69 | 704,187,492.76 | 00.00 | 1,718,204,653.17 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 479,572,191.72 | 534,444,968.69 | 704,187,492.76 | 00.00 | 1,718,204,653.17 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 24,171,755.10 | 00.00 | 24,171,755.10 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 479,572,191.72 | 533,814,051.53 | 902,018,960.71 | 00.00 | 1,915,405,203.96 |
| D01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 479,572,191.72 | 533,814,051.53 | 902,018,960.71 | 00.00 | 1,915,405,203.96 |

| | | | | | | |
|-----|---------------------------------------|----------------|----------------|----------------|-------|------------------|
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 479,572,191.72 | 533,814,051.53 | 902,018,960.71 | 00.00 | 1,915,405,203.96 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -17,141,799.39 | 00.00 | -17,141,799.39 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 479,572,191.72 | 533,814,051.53 | 884,877,161.32 | 00.00 | 1,898,263,404.57 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------|--|-----------------------|----------------|-----------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт хэмнэлт | Хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 530,283,500.00 | 529,498,990.13 | 784,509.87 | 99.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 530,283,500.00 | 529,498,990.13 | 784,509.87 | 99.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 500,931,600.00 | 500,147,090.13 | 784,509.87 | 99.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 391,691,500.00 | 391,035,935.13 | 655,564.87 | 99.8 |
| 210101 | Үндсэн цалин | 247,326,000.00 | 239,453,508.19 | 7,872,491.81 | 96.8 |
| 210102 | Нэмэгдэл | 93,074,200.00 | 104,644,893.00 | -11,570,693.00 | 112.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,096,000.00 | 15,560,000.00 | 2,536,000.00 | 85.9 |
| 210104 | Урамшуулал | 33,195,300.00 | 31,377,533.94 | 1,817,766.06 | 94.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,961,300.00 | 48,960,300.00 | 1,000.00 | 100 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,293,800.00 | 33,292,800.00 | 1,000.00 | 100 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,800,000.00 | 1,738,338.00 | 61,662.00 | 96.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,113,800.00 | 1,175,462.00 | -61,662.00 | 105.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,048,400.00 | 14,048,000.00 | 400.00 | 100 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,048,400.00 | 14,048,000.00 | 400.00 | 100 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,700,000.00 | 2,580,000.00 | 120,000.00 | 95.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,700,000.00 | 2,580,000.00 | 120,000.00 | 95.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,206,600.00 | 33,199,055.00 | 7,545.00 | 100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,186,600.00 | 31,184,322.00 | 2,278.00 | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,420,000.00 | 1,414,733.00 | 5,267.00 | 100 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 530,283,500.00 | 530,285,238.33 | -1,738.33 | 100 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 527,859,500.00 | 527,859,478.33 | 21.67 | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 527,859,500.00 | 527,859,478.33 | 21.67 | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,424,000.00 | 2,425,760.00 | -1,760.00 | 100 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,424,000.00 | 2,425,760.00 | -1,760.00 | 100 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 15,833,042.36 | -15,833,042.36 | 100 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 87,000 | | |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГИЭЛТ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей нь “Хүн амд хүргэх соёлын үйлчилгээг өргөтгөх, урлагийн бүх төрлийг хөгжүүлэх, түүнийг нийгэм эдийн засгийн бүх салбартай холбох, үндэсний уламжлалт болон сонгодог урлагийг хөхүүлэн дэмжих, соёлын урлагийн үнэт өвийг түгээн дэлгэрүүлж, сурталчлах, орчин үеийн уран бүтээлийн чанар, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрөөс баримтлах Соёлын бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлэх” эрхэм зорилготой тус байгууллага нь удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 9, гэрээт ажилтан 7 нийт 17 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Р.Пүрэвсүрэн 2024 оны 01 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл, түр орлон гүйцэтгэгч Д.Насантогтох 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын өдр хүртэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Намсрай нар зурж, Ж.Шинэцэцэг эд аж ахуйн нярваар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийгмийн даатгалын тухай, Соёлын тухай хууль, Соёлын өвийн тухай хууль, Архивын тухай, болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй. Дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-ийн стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,074.6 мянган төгрөгөөр буюу 2,3% хувиар буурч 1,898,263.4 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|------------------|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 15,920.0 | 87.0 | 15,833.0 |
| Авлага | 1,187.7 | 1,187.7 | 0,0 |
| Бараа материал | 49,706.9 | 53,940.8 | 4,233.9 |
| Үндсэн хөрөнгө | 1,853,523.2 | 1,842,207.8 | -11,315.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | 24,281.9 | 34,202.4 | 9,920.5 |
| Нийт хөрөнгө | 1,920,338.0 | 1,898,263.4 | -22,074.6 |
| Өр төлбөр | 4,932.8 | 0,0 | 4,932.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,915,405.2 | 1,898,263.4 | -22,074.6 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,920,338.0 | 1,898,263.4 | -22,074.6 |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2024 оны санхүүгийн тайлан

Түүх угсаатны зүйн музей нь 2005 онд үүссэн шуудан холбооны 1,187.7 мянган төгрөгийн авлагтай, 2024 онд өмнөх оны авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Бараа материал өмнөх оноос 4,233.9 мянга төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант жилийн зардлаас 451.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 34,202.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,400.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материал төсвийн хөрөнгөөр худалдан авч, 376.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 30,359.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,100.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материал зарцуулсантай холбоотой байна. Бараа материалын үлдэгдэл 53,924.8 мянган төгрөг байна.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн үндсэн хөрөнгө өмнөх оноос 11,682.1 мянган төгрөгөөр буурч 1,842,207.8 мянган төгрөг болсон нь тайлант оны элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 604,069.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс авах санхүүжилтийг 133,090.2 мянган төгрөгөөр хасч 470,979.9 мянган төгрөгөөр баталсан нь цалингийн зардал, хангамжийн материалын зардлыг хасч баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 319,887.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 2,185,029.2 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс авах 470,979.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлого 2,424.0 мянган төгрөг төвлөрүүлснээс гэрэл

цахилагааны зардалд 210.0 мянган төгрөгийг, 213.8 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд, 2,000.2 мянган төгрөгийг багаж техник хэрэгслийн зардалд зарцуулсан байна.

Оны эцэст улсын төсвийн хэмнэлтийн 16,619.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

| № | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|------------|-----------|-------|------|
| 1 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 411,675.9 | 411,094.1 | 581.8 | 100 |
| 2 | 80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил | 10,000.0 | 10,000.0 | 0,0 | |
| 3 | 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж | 26,258.8 | 26,258.8 | 0,0 | |
| 4 | 81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт | 20,621.0 | 20,594.6 | 26.3 | 100 |
| 5 | 83603 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,424.0 | 2,249.4 | 174.5 | 100 |
| | дүн | 470,979.7 | 470,196.9 | 782.6 | 100 |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2024 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэбулган гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын

газарт 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 470,979.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,709.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 3,061.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудит түүвэр “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар”-ын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэсэн байна. Аудитын тайлангаар 31,573.4 мянган төгрөгийн 4 шийдвэрийг өгсөн, хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн FAS системд оруулж, албан бичгээр хариуг ирүүлж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | Биелэлт |
|----------|------------------------|---------|
|----------|------------------------|---------|

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
|-----------------|----------|-----------------|----------|-----------------|------------|
| Албан шаардлага | 2 | 20,000.0 | 2 | 20,000.0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 11,573.4 | 2 | 11,573.4 | 100 |
| Нийт дүн | 4 | 31,573.4 | 2 | 31,573.4 | 100 |

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн FAS систем, ирүүлсэн холбогдох баримт, материал

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,237.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

17,772.3 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн 2,237.0 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.1. Албан шаардлага

1. *Илрүүлэлт:* ХХОАТ суутган тооцож дутуу шилжүүлсэн.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын цалин хөлснөөс суутган тооцсон ХХОАТ-ыг хуулийн хугацаанд шилжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. *Илрүүлэлт:* Жилийн эцсээр ХХОАТ-т 3,258.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8 дах заалт “Төсвийн зөв зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өглөг, авлага үүсгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2. Албан шаардлага

1. *Илрүүлэлт:* Иргэн Б.Мөнхжаргалд гэрийн үнэ 5,000.0 мянган төгрөгийг “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” өвийг сурталчилах гэсэн утгаар шилжүүлж гэрийг орлогод аваагүй шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон

цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалт, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрийг орлого авч санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.Илрүүлэлт: Ажилчдын хавсран гүйцэтгэсэн ажлын нэмэгдэл хөлсийг захиргааны зөвлөлийн шийдвэргүй олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дэхь заалт “Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын хавсран гүйцэтгэсэн ажлын нэмэгдэл хөлсийг байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн олгож байх албан шаардлагыг хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|---------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Байгууллагын нярав 2024 оны бичиг хэргийн материалыг илүү орлого авч тайлагнасан байхад байгууллагын нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байна. | 1 | 2,237.0 | | | | | 1 | 2,237.0 | | | | |
| Дүн | 1 | 2,237.0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 2,237.0 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Иргэн Б.Мөнхжаргалд гэрийн үнэ 5,000.0 мянган төгрөгийг “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” өвийг сурталчилах гэсэн утгаар анхан шатны баримт дутуу шилжүүлсэн. Гэрийг орлогод аваагүй шууд зардлаар | | | | | 1 | 5,000.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|--|---|---|---|---|---|----------|---|---|---|---|---|---|---|--|
| <p>бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалт, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн байна.</p> | | | | | | | | | | | | | | |
| <p>Ажилчдын хавсран гүйцэтгэсэн ажлын нэмэгдэл хөлсийг байгууллагын захиргааны зөвлөлийн шийдвэргүй олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дэхь заалт "Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" гэсэн заалттай нийцэхгүй байна.</p> | | | | | 1 | 9,513.5 | | | | | | | | |
| <p>ХХОАТ-ын 3,258.8 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.</p> | | | | | 1 | 3,258.8 | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | 3 | 17,772.3 | 0 | - | 0 | 0 | 0 | 0 | 0 | |